БАТЛАВ.
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.БАТЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР "БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ" /ТӨВ/ ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**2024.04.03**

| № | Тоног төхөөрөмж | Дараах техникийн үзүүлэлт хангасан (эсхүл түүнтэй дүйцэх) | Тоо, ширхэг |
|---|---|---|---|
| 1 | Теннисний ширээ /тор, бөмбөг, ракет иж бүрэн/ | **Ширээний хөл:** Төмөр хөлтэй, 9.5 см диаметртэй дугуйтай, эвхэгддэг /тавцанг өргөхөд буухаас хамгаалсан түгжээтэй/,<br>**Ширээний тавцан:** ширээний тавцан нь сайн чанарын шахмал /100% полистер материалтай/ байна.<br>**Дагалдах хэрэгсэл:** Тор, бөмбөг, зориулалтын цохиур тус бүр 10 ширхэг байна.<br>**Ширээний хэмжээ:** L2750 x W1500 x H760 мм, Тавцангийн зузаан нь 30 мм-ээс багагүй байна | 37 |
| 2 | Волейболын шон, торны комплекс | **Волейболын шон:** шон нь доошоо 40 см орох суурьтай байх ба дугуй цилиндр хэлбэртэй төмөр, өндрийн түвшинг хялбар өөрчлөх боломж бүхий тор татах хос төхөөрөмж байна.<br>**Шонгийн өндөр:** өндөр нь шалны түвшнээс дээш 2550 мм хүртэл сунах боломжтой торны өндрийг тааруулахын тулд 800 мм зайд дээш доош болгох хялбар механизмтай байна.<br>**Шонгийн суурь:** Шонг шал буюу газарт бэхлэх ба төмөр олс, татуурга, хүндрүүлэгчгүйгээр тогтоож түүнийг зөөлөн материалаар бүрнэ. Шонг тогтоогоогүй үед нүхийг заавал таглана.<br>**Тор:** торыг хар өнгийн 0.3 мм хүртэл диаметртэй мяндсан, олсон утсаар шоо дөрвөлжин сүлжиж хийнэ. Шоо дөрвөлжин нүд нь 100мм x 100мм эсвэл 45мм x 45мм хэмжээтэй байж болно. Торны дээд хүрээг 70мм хүртэл, доод хүрээг 50мм хүртэл өргөнтэй цагаан өнгийн материалаар эмжиж хийнэ. Хэмжээ нь: L9500-10000мм x W1000мм.<br>Өндөр хэмжигч нь цагаан өнгөтэй, сунадаг, дээрээ хэмжээстэй байх бөгөөд хөнгөн байна.<br>**Хязгаарлагч антен:** Хуванцар уян хатан шинж бүхий торонд хялбар бэхлэх боломжтой урт нарийхан саваа хэлбэртэй байх ба торноос дээш агаарын орон зайд тоглолтын талбайг тодорхойлох чиг үүрэг бүхий хэрэглэл. Волейболын спортын орчин болон сургалтад тавих шаардлага. MNS 6642:2016 | 37 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Волейболын бөмбөг | Синтетик лидерин үнэргүй, гадаргуу нь оёдолгүй, наалттай, дотор хэсгээрээ резинен эдлэлээр хийгдсэн, алаг бөмбөг. Бөмбөгний диаметр 650 мм, 260 гр жинтэй, доторхи даралт нь 0.3-0.325 kgf/см. Волейболын спортын орчин болон сургалтад тавих шаардлага. MNS6642:2016 | 143 |
| 4 | Онооны самбар | Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны хананд өлгөгдөх зориулалттай. Багуудын оноо болон шүүгчийн шүүлтийг үзэгчдэд ил тод харуулах, тоглогчдын тоглох идэвхийг сайжруулах, спорт заалны өнгө үзэмжийг нэмэгдүүлэхүйц өнгө ялгарал сайтай асдаг сүүлийн үеийн лед дэлгэцтэй байх. Доргилтоос хамгаалагдсан, 100 м хүртэлх зайд утасгүйгээр удирдах удирдлагатай, дотор болон гадаа талбайд ашиглах боломжтой. Мөн гар утасны программаар удирдаж болно. Огноон цаг харуулах горим: Цаг минут, гараг, байгууллага, сургууль, ивээн тэтгэгчийн нэр, орчны температур. Тэмцээнээс бусад үед дэлгэц дээр сар, өдөр, цаг, минут /бусад/-ийн мэдээлэл гарч байх. Монгол, англи үсгийн фондтой байна.<br>Жин: 40 кг хүртэл. Хэмжээ: L1900мм x W1300мм, Тэжээл, чадал: 220волт, 600ватт.<br>Холболтын төрөл: Утасгүй холболт. Дэлгэцийн төрөл: P10 LED.<br>**Үндсэн горимууд, тэдгээрийн мэдээлэл**<br>- Багуудын оноо - Багуудын нэрс (Монгол, Англи фонтоор)<br>- Үндсэн цаг<br>- Тоглолтын үе - Довтолгооны секунд (24, 14-н сонголттой, долийн нарийвчлалтай. Шаардлагагүй тохиолдолд унтрааж болно)<br>- Багуудын алдаа - Багуудын завсарлага<br>- Хосоор байж болно. Хос үед 5x5 дээр ижил мэдээлэл гаргана. 3x3 дээр тусдаа удирдагдаж ажиллана.<br>- Шийдний 24-н самбар дэмжинэ | 37 |
| | | **Нийт дүн** | **254** |

Хянасан:
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа

Боловсруулсан:
Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ш.Энхтуул